




ТунгдАуИ

- ӨГӨГДЛИЙН УРЛАН -

# ЦЭЦЭРЛЭГИЙН БҮРТГЭЛ


2019-2020 оны хичээлийн жил








## Цэцэрлэгийн насны хүүхдийн тоо Насаар, 2019 он



- 1 5 настай - 39 мянган хүүхэд
- 2 4 настай - 38 мянган хүүхэд
- 3 3 настай - 37 мянган хүүхэд
- 4 2 настай - 33 мянган хүүхэд

## Цэцэрлэгт хамрагдах хүүхдийн тоо 2019 он



- 1 Төрийн өмчийн цэцэрлэгт  
- 90 мянган хүүхэд
- 2 Төрийн бус өмчийн цэцэрлэгт  
- 33 мянган хүүхэд
- 3 Цэцэрлэгт хамрагдах боломжгүй  
- 25 мянган хүүхэд





31 мянган хүүхэд  
Цэцэрлэгийн цахим  
бүртгэлд бүртгүүлсэн




19 мянга  
Цэцэрлэгт шинээр  
элсүүлэхээр зарласан  
2-5 настай хүүхдийн орон тоо



16 мянган хүүхэд  
Цэцэрлэгт элсэхээр  
шалгарсан

# Цэцэрлэгт шинээр элсэх хүүхдийн цахим бүртгэл

 орон тоо байгаа  орон тоо байхгүй




---

 = 1000 хүүхэд



## Цэцэрлэгийн цахим бүртгэлд шалгарсан хүүхдийн хувь Дүүргээр, 2019 он





6 хүүхэд тутмын 1 нь цэцэрлэгт хамрагдах боломжгүй.





3 хүүхэд тутмын 1 нь төрийн өмчийн цэцэрлэгт хамрагдах боломжгүй.

### ЦЭЦЭРЛЭГИЙН НАСНЫ ХҮҮХЭД

2019 оны байдлаар нийслэлийн хэмжээнд цэцэрлэгийн насны (2-5 нас) 148 мянган хүүхэд байгаагаас 2 настай 33 мянган хүүхэд, 3 настай 37 мянган хүүхэд, 4 настай 38 мянган хүүхэд, 5 настай 39 мянган хүүхэд байна.

### ЦЭЦЭРЛЭГИЙН ХҮРЭЛЦЭЭ

2019-2020 оны хичээлийн жилд нийслэлд төрийн өмчийн 260 цэцэрлэг, төрийн бус өмчийн 454 цэцэрлэг буюу нийт 714 цэцэрлэг ажиллахаар байна. Төрийн өмчийн цэцэрлэгт 90 мянган хүүхэд хамрагдах бол төрийн бус өмчийн цэцэрлэгт 33 мянган хүүхэд хамрагдах боломжтой. Үлдсэн 25 мянган хүүхдийг суралцуулах цэцэрлэг дутагдалтай байна. Цэцэрлэгийн хүртээмжээр тооцсон цэцэрлэгт хамрагдалтын хувь 83% байна.

### ЦЭЦЭРЛЭГИЙН ЦАХИМ БҮРТГЭЛ

Тухайн жил цэцэрлэгт шинээр хамрагдах 2 настай хүүхдүүд болон шинээр элсэж орох 3-5 настай хүүхдүүдийг цахимаар бүртгэдэг. Улмаар бүртгүүлсэн хүүхдийн тоо тухайн цэцэрлэгийн зарласан орон тооноос хэтэрсэн бол систем дээр санамсаргүйгээр шалгаруулж элсэлтийг зохион байгуулдаг. Энэ жил цахим элсэлтээр төрийн өмчийн 242 цэцэрлэгт 2-5 настай хүүхдийн нийт 18,720 орон тоо зарлагдаж, 31,340 хүүхэд бүртгүүлснээс харьяалал, насны дагуу нийт 15,647 хүүхэд шалгарсан байна.

### ӨГӨГДЛИЙН ЭХ ҮҮСВЭР

Нийслэлийн боловсролын газар, Үндэсний статистикийн хороо